

МОННООС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04-р сарын 29 өдөр

Дугаар №01.20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2020 оны 4-р сарын 29-ны өдрийн 15.00 цагт эхлүүлсэн.

ХЭХурлын дарга: Э.Тогосмаа /Ариг гал ХК-н ня-бо/

Тооллогын комиссын дарга: Б.Цолмон /Кашмер Холдинг ХХК-н Арилжааны хэлтсийн дарга/

Тооллогын комиссын гишүүн: Д.Даваасүрэн /Монноос ХК-н Ерөнхий менежер/

С.Бадарч /Монноос ХК-н нярав/ нар ажилласан.

Хуралд оролцсон Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапил- 69732ш
2. Адам Холдворсын итгэмжлэлээр Х.Эрдэнэбаяр-69824ш
3. С.Алимаа-14443ш,
4. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Х.Эрдэнэбаяр-69824ш
5. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр Д.Мөнхбат-15274ш
6. Д. Ариунболдын итгэмжлэлээр Л.Гантуяа-6135ш

Монноос ХК-ийн нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 250514ш хувьцаа эзэмшигч буюу 71,4%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж үзээд хурлыг 15 цаг 00 минутад эхлүүлж, 1 цаг 30 минутад багтаан явуулахаар тогтоов.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга Э.Тогосмаа танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Монноос ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан
2. Монноос ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт
3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох
4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл
6. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, саналын дүнг гаргах, ХЭХ-д саналын дүнг танилцуулах

Хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааг Х.Эрдэнэбаяр танилцуулав.
 - 2019 онд түрээсийн үйл ажиллагаа явуулж ажилласан. Ноосны агуулахууд, дулаан, цахилгаан, цэвэр бохир усны шугам бүхий үйлдвэрлэл, оффисын байр талбайнууд болон гаднах зам талбайг түрээслэж, 14 аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй түрээсийн гэрээ байгуулж, нийт 117,8сая.₮-ийн орлого олж, 116,5сая.₮-ийн зардал гаргаж, 1,3сая.₮-ийн ашигтай ажилласан.
 - Ноос угаах шугамыг шинэчлэн засварлан ашиглалтанд оруулсан.
 - Хөрсний уснаас шалтгаалан КНС болон бохирын шугамын ачаалал ихэссэн.

- Монноос ХК-ийн Нисэхийн эзэмшил газруудын гэрээ гэрчилгээнүүдийг 15жилээр сунгуулсан.
- Монноос ХК-ийн ноос угаах үйлдвэрлэлийг сэргээн босгох Сайжруулалтын төлөвлөгөөний дагуу ноос угаах 5 шугамын угаах онгоц, хатаах машин, пресс машин гм тоног төхөөрмжүүдийн иж бүрэн засварыг хийсэн.
- Монноос ХК-ийн 8 давхар оффисын барилгад орон сууц, цэцэрлэг болгох төслийн ажлыг гүйцэтгүүлсэн.
- Нолго ХХК –аар дамжуулан өндөр тарифаар цахилгааны хангалт авч алдагдалд орж байсанг болиулж Ариг гал ХК-аас цахилгааны тэжээл авах талаар Ариг гал Хк-аас зөвшөөрөл авсан.

2. Монноос ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн аудитын хорооноос өгсөн дүгнэлтийг нарийн бичиг М.Тунгалаг танилцуулав.

ТУЗ-ийн аудитын дэд хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Бүрэнтэгшийн дүгнэлтэнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болох ноос угаах шугамаа сэргээн засварласан.
 - Монноос ХК-ийн гаднах дулаан болон уурын шинэ шугамын угсралтын ажлыг хойшлуулсныг яаралтай хийлгэх шаардлагатай.
 - Ашиглахгүй байгаа мал эмнэлгийн байр, зоорь, бусад эзэмшил газруудын ашиглалтыг сайжруулах, түрээслэх, үйл ажиллагаа явуулах үэргээ эдийн засгийн эргэлтэнд оруулахыг Компанийн гүйцэтгэх удирдлагад шаардаж байна.
 - Нолго ХХК-аар дамжуулан авдаг цахилгааны тэжээлийг Ариг гал ХК-ийн дэд станцаас шууд тэжээл авч, хойшид алдагдалгүй ажиллахыг дэмжиж байна.
 - 8 давхар оффисын барилгын хэмжилт, зураг төслийн зургийг шинэчлэн хийлгэж, түүнийг орон сууц, нийтийн байр, цэцэрлэгийн зориулалтаар ашиглах төслийн ажлыг шинэчлэн хийлгэсэн.
 - Нисэхэд байрлах аж ахуйн зориулалт бүхий эзэмшил газрын асуудлыг шийдвэрлэсэн.
- Энэхүү аудитын дүгнэлтээс Монноос ХК ГЗахирал Эрдэнэбаярыг 2020 оны үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнд хүргэж ажиллахыг шаардаж байна.

3. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох

ТУЗ-ийн энгийн гишүүд: С.Мөнхжаргал- Кашмер Холдинг ХХК ГЗ

Адам Холдсворт- NPEAL ХХК ГЗ

С.Алимаа- Дизайн концепт ХХК ГЗ

Х.Эрдэнэбаяр- Монноос ХК ГЗ

Ц.Цэнгэлбаяр- Ариг гал ХК Ерөнхий ня-бо

П.Оюунбаяр- Кашмер Холдинг ХХК менежер

ТУЗ-ийн хараат бус гишүүд: Л.Бүрэнтэгш-БЦД ХХК ГЗ

И.Сэр-Од- Монголын бизнесийн зөвлөлийн дэд захирал

Х.Оюунгэрэл- Бадрах өгөөж ХХК ГЗ нарыг ХЭХуралд оролцогчдын 100%-ийн саналаар томилов.

4. Компанийн удирдлагын зардлыг ТУЗ-ийн нарийн бичиг М.Тунгалаг танилцуулав.

Монноос ХК-ийн 2019 оны санхүүгийн балансаар 117,8ая.₮-ний орлого олж, 116,5ая.₮-ийн зардал гаргаж, татварын өмнөх ашиг 1,3ая.₮, татварын дараах цэвэр ашиг 1,2ая.₮ ажилласан.

Монноос ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг жилд 2,1ая.₮-өөр төлөвлөхийг батлав.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Мөнхбат –Ноос угаах үйлдвэрлэлийг ашиглалтанд оруулсан нь сайн байна. Ноос угаалгах захиалагч компаниудын захиалга авч, борлуулалтаа өсгөх хэрэгтэй.

Эрдэнэбаяр – Ноолуур хөтөлбөрийн шугамаар ноолуурын компаниудын ноолуур угааж боловсруулах ажил хийгдэх төлөвлөгөөтэй байгаа. 2019 онд Кашмер Холдинг ХХК-тай хамтран ажиллах гэрээ хийгдсэн.

Гиваапил- Нолго ХХК-аас татдаг цахилгааны эх үүсвэрийг Ариг гал ХК-аас эртхэн холболт хийлгэх хэрэгтэй. Сүүлийн 3,4 жил маш их алдагдал хүлээсэн байна.

С.Алимаа - Орон сууц, цэцэрлэг сургуулийн зориулалттай ашиглах томоохон ажлуудыг эхлүүлэхдээ бизнес төлөвлөгөө боловсруулж ажиллаарай.

Эрдэнэбаяр- Алимаагийн саналыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана

6. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж Тооллогын комиссын дарга Б.Цолмон танилцуулав.

ХЭХурлаас гарсан шийдвэр:

1. Монноос ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг 100%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн энгийн гишүүнээр кумулятив саналаар Адам Холдсворт, С.Мөнхжаргал, С.Алимаа, Х.Эрдэнэбаяр, Ц.Цэнгэлбаяр, П.Оюунбаяр нарыг тус тус сонгосныг батлав.
3. ТУЗ-ийн хараат гишүүнээр кумулятив саналаар Л.Бүрэнтэгш, И.Сэр-Од, Х.Оюунгэрэл нарыг тус тус сонгосныг батлав.
4. Компанийн 2020 оны удирдлагын зардлыг батлав.

Тэмдэглэл бичсэн: Хурлын дарга

Хурлын нарийн бичгийн дарга

Э.Тогосмаа

М.Тунгалаг